

Мохаммад Садли

Индонезийн Сангийн яамны сайдаар олон жил ажилласан, эдийн засгийн профессор М. Садлитай энэ 1992 оны 4 дүгээр сард Жакарт хотод уулзах завшаан тохиолдсон билээ. Индонез шинэ тулгар хөгжиж байгаа эдийн засгаа тогтворжуулах, мөнгөний ханш бууралттай тэмцэхийн тулд үндэсний мөнгөн тэмдэгт-рупийнхээ ханшийг 2-3 удаа бууруулсан тухай тэр бидэнд хуучилсан юм. «Эйнауик» сэтгүүлийн тоо баримтаас үзвэл 183 сая хүн амтай Индонезийн нэг хүнд ногдох ҮНБ 605 ам. доллар, эдийн засгийн өсөлт жилд 5 хувь, жилийн экспортын бүтээгдэхүүний өртөг 29,1 тэрбум ам. доллар, гадаад өрийн хэмжээ 65,7 тэрбум ам. доллар юм байна. Тэрээр бидэнд өөрийн бичсэн Индонезийн туршлагын тухай өгүүллээ дурсгасныг орчуулан Та бүхэндээ толилуулж байна.

Сэтгүүлийн редакц

1. Түүхэн хөрс дэвсгэр

Шинээр тусгаар тогтносон орнуудад улс төрийн болон бусад хөгжлийн үйл явц түүхэн хүчин зүйлээс ихээхэн хамаардаг. Индонез урьд нь өрнөдийн хуучин колони орон байгаад дэлхийн II дайны дараа цус урсгасан тэмлээр тусгаар тогтнолоо олсон улс юм. Тиймээс ч улс төр, эдийн засгийн радикал үзэл тусгаар тогтнолоо олсны дараах эхний 20 жилд нөлөөтэй байсан. Юуны өмнө хуучин колонийн эзэдтэйгээ улс төрийн тохиролцоонд хүрэх хэрэгтэй байв. 1949 оны 12 дугаар сард эдийн засгийн статус квог хэвээр хадгалах нөхцөлд бүрэн эрхт байдлаа олж авсан юм.

Тухайн үедээ удирдах давхаргын дунд нөлөөтэй байсан эдийн засгийн философи нь шинээр тусгаар тогтносон бусад орны нэгэн адил социалист үзэл санаа байлаа. ЗХУ-д хэрэгжүүлж байсан төвлөрсөн төлөвлөгөөт загварыг улс орныг шинэчилж, ядуу байдлаас ангижруулах хамгийн түргэн арга зам гэж тооцож байв. Хэдий тийм ч тэр үедээ хөгжиж байгаа орны олонх нь бүрэн нийгэмчилсэн эдийн засагтай марксист моделийн төлөө байгаагүй юм. Худалдаанд хувийн хэвшил, мөн газар тариалангийн жижиг үйлдвэрлэгчдийг хөндөлгүй орхижээ. Гэвч Засгийн газар худалдааны улсын компанийг дэмжин, газар тариалангийн томоохон аж ахуйг хөгжүүлэх болов. Төлөвлөлт, ялангуяа улсын хөрөнгө оруулалтанд хамаарах төлөвлөлтийг эдийн засгийн хөгжлийн чухал хөшүүрэг гэж үзэж байв. Түүнчлэн засгийн газар нэн хэрэгцээтэй хэмээгдэх олон тооны бараа таваар, үйлчилгээний үнэ өртгийг шууд зохицуулж, аж ахуйн үйл ажиллагааг ч лицензээр дам куулан төвлөн удирдаж байлаа. Аж үйлдвэржүүлэлт ч төрийн хатуу ивээлд импортыг орлох чиглэлтэй явагдаж, төрөөс олон төслийг санаачлан хэрэгжүүлж байв. Гадаадын хөрөнгө оруулалтыг ч төрийн ивээлд байгаа салбарт чиглүүлж байв. Тухайлбал, үндэсний газрын тосны компани дөнгөж бүрэлдэж байсан 50-аад онд Индонезийн газрын тос олборлох салбар ийм салбарын нэг байв.

Улс оронд валютын нөөц дутагдаж байсан нөхцөлд гадаад худал дааг чухалчилж байсан боловч экспортыг хөгжүүлэх чиглэл тогтох

болоогүй байв. Урьдын колони байсан хэв загвараар уул уурхайн бүтээгдэхүүн болон түүхий газрын тос зэрэг анхдагч бүтээгдэхүүнийг экспортод гаргасаар иржээ. Боловсруулсан бүтээгдэхүүн экспортлох ажил хожим эхэлсэн билээ.

2. Эхний үеийн системийн алдаа дутагдал

Индонезэд ийм загварын улс төрийн эдийн засаг 20 орчим жил үргэлжилж, тус орны анхны ерөнхийлөгч Сукарногийн үетэй давхацдаг. Тэрээр гол төлөв улс төрийн, тухайлбал, колонийн үлдэгдлийн эсрэг үндэсний фронт байгуулах болон «улс үндсээ бэхжүүлэх» зорилгод түлхүү анхаарчээ. Олон улсын тавцанд ч колонийн эсрэг, империализмийн эсрэг хөдөлгөөнд Индонезийн нөлөөг өргөтгөхөд үйл ажиллагаагаа чиглүүлэв. Ийм бодлого нь эцсийн дүндээ Өрнөдийн орнууд, мөн НҮБ, Дэлхийн банк, ОУВС зэрэг байгууллагаас хөндийрөхөд хүргэсэн байна.

Сукарно эдийн засагт бага анхаарч байсныг хэлэх хэрэгтэй. Тэр үед улсын хөрөнгө оруулалт шаардлагатай болоход татварын журмаар зохих хөрөнгө цуглуулахыг колонийн дэглэмийн буруу арга барил хэмээн зөвшөөрдөггүй байв. Харин цаасан мөнгө үйлдвэрлэхийг юуны түрүүнд хичээдэг байлаа. Энэхүү санхүүгийн арга Мөнгөний ханш асар ихээр унахад хүргэж, өнөөдрийн тэс өөр нөхцөлд ч Засгийн газар тэр үеийн уршгийг бүрэн давж туулаагүй л байна.

Хуучин дэг журам хэмээгдсэн энэхүү бодлого 1965—1966 онд улс төрийн ч, эдийн засгийн ч хувьд дампуурсан билээ. Мөнгөний ханш бууралтын хэмжээ жилд бараг 600 хувьд хүрч, үндсэндээ газрын тос, каучукаас орох экспортын орлого дөнгөж хэдхэн зуун сая долларт эргэлдэж байв.

Сукарногийн дараа Сухарто ерөнхийлөгч болж, засгийн эрхэнд гарсан. Энэхүү өөрчлөлтийн хувьсгалч шинж чанараас шалтгаалан шинэ тогтсон дэглэм радикал, алс хэтийн үр дагавартай шинэчлэлт хэрэг жүүлэхээр зориглов. Хэт төвлөрсөн эдийн засгийг зах зээлийн мэдрэмжтэй болгох алхмууд хийсэн боловч либералчлах үйл явц дөнгөж эхлэлийн төдий байлаа. Хүнс, хувцас, бусад өргөн хэрэгцээний зүйлээр гачигдсан хэвээр байсан учир олонх бараа, үйлчилгээний үнэ төлбөрийг Засгийн газар анхандаа хянаж байв. Нөгөө талаас шинэ Засгийн газар урьд нь голландчууд санаачилсан гадаад валютын хяналтын системийг нэг далайлтаар л өөрчлөв. Шинэчлэлийн эхэн үед гадаад валютын хүртээмжийг сайжруулах үүднээс Сукарногийн үеийн олон зүйлийг хянан засварлажээ. Шинэ Засгийн газар Өрнөдтэй хэл амаа ололцож, гадаад өр төлбөрийн асуудалд зохицуулалт хийн, гадаадын тусламж, хөрөнгө оруулалтыг татах талаар нэлээд ажил хийв.

Урьд нь улсын болгосон байсан үйлдвэрийн газруудыг хуучин эздэд нь буцаан өгч, бодлогодоо үнэнчээ харуулав. Газрын тос олборлох чиглэлээр өрнөдийн компанийг урамшуулах арга хэмжээ авлаа. ОУВС болон Дэлхийн банктай харилцаагаа сэргээн бататгав.

Ийнхүү шинэ дэг журам хэмээгдэх эдийн засгийн бодлого тун ч удалгүй үр шимээ өгч эхэллээ. Улсын төсвийн асар их алдагдлыг багасгахад гаднын тусламж ч зарим талаар нэмэр болов. Ингэснээр Тэнцвэртэй төсвийн зарчимд шилжиж, тэр зарчим нь өнөөг хүртэл мөрдөгдөж байна. Хэдийгээр дотоодын орлого зарлагын тэнцвэр жинхэнэдээ хангагдаагүй боловч төсвийн алдагдлыг гаднын тусламжаар нөхөхөөр олон улсын донорын байгууллагатай тохирчээ. Үүний гол зорилго нь хэт их мөнгө үйлдвэрлэж санхүүжүүлдэг явдлыг зогсооход

чиглэжээ. Мөнгөний ханш бууралт үүний дүнд нэг оронтой тоогоор илэрхийлэгдэх болов. Өнгөрсөн алдааг засаж, эдийн засгийг үр ашигтай сэргээн босгосноор өсөлтийн хурдац ч нэмэгдэв.

70-аад онд Засгийн газар хоёр ч удаа газрын тосны орлого их хэмжээгээр хүртэв. Ингэснээр аж үйлдвэржүүлэх Засгийн газрын санг нэмэгдүүлсэн төдийгүй олон тооны дэд бүтцийн төслийг хэрэгжүүлэхэд гадаадын капиталтай хавсрах дотоод хөрөнгийг бүрдүүлж өгчээ. Ер нь 60-аад оны сүүлч, 70-аад оны эдийн засгийн өсөлтийг Засгийн газрын тэргүүлэх үүрэг, газрын тосны орлого болон гаднын тусламж, зээллэгтэй холбон үзэж болно. Их хэмжээний хөрөнгө оруулалтыг үл харгалзан эдийн засгийн хурдац жилийн дунджаар 8 хувь байснаа эхлээд 7 хувь, дараа нь 6 хувь хүртэл буурав. Сүүлдээ таван жилийн дунджаар жилд 5 хувь болж тогтворжсон нь дэд бүтэц болон газрын тос боловсруулах салбар, бордоо үйлдвэрлэл, ган боловсруулах цогцолборт их хэмжээний улсын хөрөнгө оруулалт хийсэнтэй холбоотой.

Гадаадын хөрөнгө оруулсан салбарт хамтын үйлдвэрийн хэлбэрээр хувийн хэвшил бойжиж байв. Гэвч дотоодын хувийн хэвшил дөнгөж үүсэл төдий, улсын үйлдвэрийн салбартай зүйрлэх аргагүй байлаа. Хэдий тийм ч улсын том банкууд үндэсний хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан аж үйлдвэр, усан болон автозамын Тээвэр, ойн аж ахуй зэрэг салбарт хөнгөлөлттэй зээллэгийг их хэмжээгээр олгосон юм. Засгийн газрын эдгээр зээллэг дотоодын хувийн хэвшил өсөж өндийхөд тус болжээ. Улсын үйлдвэрийн газрууд ч зарим үед Дэлхийн банкнаас ч их хэмжээний хөрөнгө оруулалт авч байлаа.

Нийтэд нь авч яривал, Засгийн газрын зүгээс лиценз, үнийн хяналт, улсаас тогтоосон валютын ханш зэрэг олон хэлбэрээр эдийн засгийн шууд зохицуулалт хийгдэж байв. Гадаад худалдааны салбарт байдал арай чөлөөтэй байсан. Хэдийгээр зарим чухал барааг улсын хангамжийн газраас хянаж, улсын худалдааны компани Ихэнх төрлийн барааг импортлох монополи эрхтэй байсан боловч импортын зарим хэсэг лицензээс гадуур хийгдэж байв. Энэ нь төрийн зохицуулалтын нэгэн хэлбэр мөн. Нэн хэрэгцээт бус хэрэглээний бараа, аж үйлдвэрийн түүхий эдийн дийлэнх, тоног төхөөрөмжийн импорт чөлөөтэй явагдаж байв. Экспорт чөлөөтэй байсан боловч хэт өндөр тогтоосон валюттай харьцах ханшнаас болж хохирох явдал гарч байлаа. Мөн хэт өндөр өөрийн өртгөөс хамааран боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт ашиг багатай байсан гэж хэлэхэд болно. Дотоод хэрэгцээг хангах үүднээс зарим экспорт хоригтой байв. Экспортын өсөлт ийнхүү үйлдвэрлэлийн өртөг болон газрын тос, байгалийн хийн үнээс хамааралтай. Түүхий эдийн экспортын үнэ 70-аад онд өндөр байсан боловч 80-аад онд буурах төлөвтэй болжээ.

3. Хөгжлийн гарааны загварын согогтой тал

Энэхүү загварын төрөлхийн согог нь 80-аад оны эхээр газрын тосны үнэ огцом унаж, бусад түүхий эдийн үнэ буурахтай зэрэг улам ил тод болов. Эдийн засагт төлбөрийн тэнцэл алдагдаж, гадаад худалдааны алдагдал өслөө. Засгийн газраас төлөх ёстой гадаад өр төлбөрийн хүү их хэмжээгээр нэмэгдэв. Энэ нь ялангуяа газрын тосны зах зээлийн төлбөрийн хэрэгсэл болох америк доллараар хэмжигдэн өсөж ирэв. Амьдралын төвшин сайжирч, үйлдвэрийн тоног төхөөрөмж шинэчлэх шаардлагыг дагалдан импортын хэмжээ түргэн өсөх болов. Газрын тосны үнийн огцом уналт, гадаад өртөлбөрийн дарамтаас шалтгаалан засгийн газрын төсөв хөгжлийн олон төслийг санхүүжүүлэх эх үүсвэрийн чадвараа алдав. Ямар нэгэн шийдвэртэй өөрчлөлт хийхээс өөр аргагүй байдал үүсжээ.

4. Либералчлах бодлогын хоёр дахь үе

1986 оноос өмнө гадаад валюттай харьцах үндэсний валютын ханшийг хатуу барьж, тогтвортой байлгах бодлого явуулж иржээ. Энэ нь мөн мөнгөний ханш буурах явцыг хязгаарлахтай уялдаатай. Гэвч үндэсний мөнгөний ханш бууралт нэг оронтой тооноос давах хандлагатай, зарим үед хоёр оронтой ч болж байв. Дотооддоо мөнгөний ханш ихээх унасан нөхцөлд валюттай харьцах ханшийг хатуу барих нь осолтой байдаг. Гадаад өр, түүний төлбөрийн хүү нэмэгдэхийн сацуу төлбөрийн тэнцлийн алдагдал ч өсөж ҮНБ-ий 3—4 хувьд хүрэх болов. Засгийн газар ч 1983 онд үндэсний мөнгөн тэмдэгт рупийгийн солилцооны ханшийг их хэмжээгээр бууруулахаас өөр аргагүйд хүрчээ. 1986 онд төлбөрийн тэнцлийн хямрал дахин давтагдаж, рупийгийн ханшийг бүр 40 хувиар бууруулав. Түүнээс хойших жилүүдэд Засгийн газар рупийг чөлөөтэй хэлбэлзэх ханштай болгосон тул жилд 6 хувь орчмоор буурч ирэв. Энэ нь зах зээлийн бодот байдлыг тооцсон нэгэн алхам байлаа.

Ер нь 1986 оноос хойш төвлөрсөн эдийн засгийг задалж, зах зээлийн хүч үйлчлэх нөхцөлийг бий болгох дорвитой алхмууд хийгдэв. Үүний эхний шатанд гадаад худалдаа хамрагдав. Худалдааны тарифыг багасгаж, тарифын бус саад хоригийг цөөрүүлжээ. Аж үйлдвэржүүлэх бодлогыг ч чөлөөтэй болгож, лицензийн хяналтыг сулруулав. Дараагийн ээлжинд банкны тогтолцоо, хөрөнгийн бирж, даатгал зэрэг санхүүгийн салбарт өөрчлөлт хийв. Ингэхэд үзэл суртлаас хавьгүй илүү бодот хэрэгцээ шаардлага байсныг хэлэх хэрэгтэй. Энэ нь ч хэвийн үзэгдэл болно. Хамгийн чухал нь Засгийн газар шинэ хэрэгцээ шаардлагыг тусган авах хэр чадвартай вэ, гаднын даралт шахалт дотоод ашиг сонирхлоос давамгайлж байна уу гэдэгт оршино. Мөн зарим үед байгаа байдлыг хэвээр хадгалан, хамгаалах гэсэн хандлага ч ажиглагддаг. Аливаа өөрчлөлт нь алдах, онохыг хослуулж байдаг.

Индонезэд төвлөрсөн эдийн засгийг задлах явц улс төрийн системийн онцлогтой холбоотой байв. Парламент болон улс төрийн намуудтай харилцах Засгийн газрын байр суурь ихээхэн хүчтэй төдийгүй арга барил нь технократ шинжтэй. Нөгөө талаас, Засгийн газар шилжилтийн үед амьжиргаа нь буурсан бага орлоготой хүмүүсийн хэрэгцээг анхаарахгүй байж чадаагүй. Засгийн газар тэтгэлгийн бодлогоо санхүү болон мөнгөний бодлогоор дамжин хэрэгжүүлэв, Санхүүгийн хүрээнд бага орлоготой хүмүүст зориулах зардлыг ядаж тоон хэмжээнд бууруулахгүй байх, харин компани, корпорац болон баян чинээлэг хүмүүсээс авах орлогын татвар хураалтыг цэгцэлжээ. Түүнчлэн, Төсвийн орлогыг нэмэгдүүлэх нэгэн үр ашигтай эх үүсвэр нь гүйлгээнээс татах татвар болсон байна.

Мөнгөний бодлого нь цаасан мөнгөний ханш буурахыг хязгаарлахад оршиж байв. Нөгөө талаас, банкны зээллэг чөлөөтэй авч байх гэсэн даралт шахалт хүчтэй байлаа. Өнөөгийн байдлаар Индонез банкны хүүгийн хувиар Азидаа хамгийн өндөр орон болж хувирчээ. 1987 оноос хойших банкны тогтолцоонд гарсан өөрчлөлт ийм байдалд хүргэжээ. Шинээр нээгдсэн банк, түүний салбарын тоо олширч, улсын банкны хэрэглэгчдийг хувийн банк олон тоогоор өөртөө татах болов.

1987 оноос хойш эдийн засагт бий болсон өөдрөг байдал нь Япон, Өмнөд Солонгос, Тайван зэрэг орон биеийн хөдөлмөрийн багтаамж ихтэй үйлдвэрийн газруудаа Зүүн өмнөд Азийн орнуудад шилжүүлэх болсонтой холбоотой. Энэ үйл явцын дүнд Индонезэд гаднын хөрөнгө капитал ихээр орж ирэн, төлбөрийн тэнцлийн алдагдлыг улам хурцатгах болов. Засгийн газар гаднын асар их зээллэгт тулгуурлан эдийн

засгаа хөтөлж байна. Энэ нь их осолтой үйл ажиллагаа болно. Урьд газрын тосны орлого их байсан үеийнх шиг Засгийн газар олон тооны төсөлд их хэмжээний хөрөнгө оруулалт хийхээс түдгэлзэх болсон нь сайшаалтай. Гэвч хувийн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн, ялангуяа улсын газрын тосны компани болох Пертамина мэтийн улсын компанийн оролцоотой аж үйлдвэржүүлэх явцыг түргэтгэх гэсэн оролдлогоо орхихгүй байна.

Хувийн хэвшил өсөхийн хэрээр янз бүрийн асуудал ч хуримтлагдана. Олонх компани, хувийн эздийн хувьд шударга өрсөлдөөний зарчим мөрдөгдөх эсэхээс хувь заяа нь шалтгаална. Засгийн газрын дэмжлэгтэй монополи эрхийг хязгаарлах шаардлагатай. Засгийн газар өөрийн байгуулсан томоохон банк, улсын үйлдвэрийн газраар дамжуулан нэг хэсэг бүлгийг нөгөөгөөс санаатай буюу санаагүй ч гэсэн илүүд үзэх нь зохимжгүй.

5. Цаашдын хандлага

Эдийн засгийн өсөлт, улс төрийн тогтвортой байдал, нээлттэй бодлого, төвлөрсөн механизмыг задлах удаа дараагийн алхам зэргийг тооцвол Индонезийн ирээдүй өөдрөг байна. 80-аад оны дундаас эхэлсэн өөрчлөлтөөс хойш эдийн засаг өсөлтийн шинэ шатанд гарч, жилд дунджаар 6 орчим хувь өсөх болов. Энэ нь нэлээд өргөн аж үйлдвэржих явцыг хамарсан, чадавхи сайтай хувийн хэвшилд тулгуурласан, хурдан хөгжиж байгаа Зүүн Ази болон Зүүн өмнөд Азийн эдийн засагтай ч харилцан уялдаатай.

Тайланд, Малайз, Филиппин зэрэг оронтой харьцуулахад Индонезийн улс төрийн түүх ялгаатай учир өөрийн гэсэн онцлогтой байх нь ойлгомжтой. Индонезийн хөгжилд Засгийн газар голлох үүрэгтэй байх Гэсэн хандлага хэвээр үргэлжлэх нь дамжиггүй. Харин түүний бодлого, арга хэрэгсэл өөрчлөгдөж байх болно. Төвлөрсөн механизмыг задлах, үндэсний эдийн засгийг дэлхий нийтийн жишигт хүргэх гэсэн өнөөгийн бодлогыг цаашид баримтлах шаардлагатай. Нөгөө талаас, Индонез мэтийн томоохон орнууд улсын тэргүүлэх салбараа хамгаалах сэтгэлгээтэй байдаг учир дотоод эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан тийм сэтгэлгээ давамгайлахыг үгүйсгэх аргагүй.

Тайланд чөлөөт худалдааны бүс нутаг байгуулах замаар эдийн засгийн интеграцаа өргөтгөхийг АСЕАН-ы орнуудад уриалсан. Хэрвээ энэхүү бодлогыг 1992 оны 1 дүгээр сард болох АСЕАН-ы дээд хэмжээний уулзалтаас дэмжих юм бол Индонез бүс нутгийн орнуудтай бодлого, систем, хэмжүүрээ нэгтгэн зохицуулснаар одоогийн бодлогоо тогтворжуулж, түүнээс ухарч буцах явдал нь багасах учиртай. Эцсийн эцэст бид АСЕАН-аар товросон шинэ улс төр, институтийн хүрээнд хамтран ажиллах болно. АСЕАН-аас гадна мөн Номхон далайн сав газарт бодлогыг зохицуулах үүрэгтэй засгийн газар хоорондын байгууллага АПЕК-ыг нэрлэж болно. Индонезийн дотоодод явагдаж буй төвлөрсөн эдийн засгийг задлах, гадаадад улам нээлттэй байх үйл явцыг бүс нутаг, олон улсын хамтын ажиллагааны хүрээнд батжуулах нь нэн чухал юм.

Англи хэлнээс орчуулсан **Ц. Батбаяр**